

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүний ба үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, Үндсэн хуулиар тогтоосон Монгол Улсын төрийн байгууллыг хамгаалах үүднээс төрийн нууцыг тогтоох, хамгаалах, ил болгохтой холбогдон үүсэх нийгмийн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

2.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “нууцын эрхлэгч” гэж тухайн байгууллагад хадгалагдаж байгаа нууцлах мэдээллийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн албан хаагчийг;

2.1.2. “нууцын зэрэглэл” гэж төрийн нууцыг задруулснаас учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран ангилж бүлэглэснийг;

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь байгууллага, хувь хүний нууцад хамаарахгүй.

3.2. Төрийн нууцтай холбогдсон харилцааг зөвхөн энэ хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН НУУЦЫН ОЙЛГОЛТ, ЗҮЙЛС, АНГИЛАЛ

4 дүгээр зүйл. Төрийн нууцын тухай ойлголт

4.1. Задруулбал Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол /хор уршиг, хор аюул/ учруулах үндэслэлтэй гэж үзэж Улсын Их Хурлаас хуулиар тогтоон нууцлан хамгаалж буй зүйлсийг төрийн нууц гэнэ.

5 дугаар зүйл. Төрийн нууцын зүйлс

5.1. Төрийн нууцын зүйлс нь мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа /цаашид “мэдээлэл” гэх/ байна.

5.2. Төрийн нууцын зүйлс нь томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник, технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр илэрхийлэгдэж болно.

5.3. Төрийн нууцын зүйлс /мэдээлэл/-д дараахь зүйлсийг хамааруулахгүй:

5.3.1. хүн амын аюулгүй байдал, эрүүл мэндэд аюул учруулах үйл явдлууд, байгалийн гамшиг, тэдгээрийн талаархи урьдчилсан мэдээлэл;

5.3.2. хүрээлэн байгаа орчны байдал, стастикийн мэдээлэл, гэмт хэргийн нөхцөл байдал;

5.3.3. онцгой эрх, төрөөс иргэд, албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжид олгож буй хөнгөлөлт, нөхөн төлбөр;

- 5.3.4. хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тухай мэдээ, баримт;
- 5.3.5. төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдал;
- 5.3.6. төрийн байгууллага, түүний албан тушаалтны хууль бус үйлдлийн тухай мэдээлэл;
- 5.3.7. төрийн нууцад хуулиар хамааруулснаас бусад улсын төсвийн орлого, зарлага;
- 5.3.8. хуулиар хориглоогүй бусад бүх мэдээлэл.

6 дугаар зүйл. Төрийн нууцын ангилал, төрийн нууцын жагсаалт

6.1. Төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцлах зорилгоор нь дараахь ангилалд хуваана:

6.1.1. улсын оршин тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд хүчээр заналхийлэх, хүч хэрэглэхээс хамгаалах, эсхүл түүнд хариу цохилт өгөх чадвар бий болгох;

6.1.2. улсын эдийн засгийн хүчийг сааруулахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;

6.1.3. гадаад харилцаанд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх.

6.2. Энэ хуулийн 5.1-д заасан ангиллын дагуу төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тусгай хуулиар тогтоож, түүнд өөрчлөлт оруулах, жагсаалтаас хасах харилцааг мөн хуулиар зохицуулна.

6.3. Төрийн нууцад хамаарах мэдээллийг төрөлжүүлэн ангилж, эсхүл тодорхой мэдээллийг нэр заан жагсаалтад тусгана.

6.4. Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар тогтоосон төрийн нууцыг хэлэлцэж буй Улсын Их Хурлын чуулган, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Засгийн газрын хуралдаан, сайдын зөвлөлийн хурал зэрэг төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг төрийн нууцын нэгэн адил нууцалж хамгаална.

7 дугаар зүйл. Төрийн нууцын зэрэглэл, түүнийг тогтоох, өөрчлөх үндэслэл

7.1. Төрийн нууц нь дараахь зэрэглэлтэй байна:

7.1.1. онц чухал-маш нууц;

7.2.2. маш нууц;

7.2.3. нууц.

7.2. Төрийн нууцын зэрэглэлийг төрийн нууцын жагсаалтыг тогтоож буй хуульд тусгана.

8 дугаар зүйл. Мэдээллийг нууцлах хугацаа, түүнийг өөрчлөх, дуусгавар болгох үндэслэл, журам

8.1. Онц чухал-маш нууц зэрэглэлийн төрийн нууцыг нууцлах дээд хугацаа 30 жил, маш нууц зэрэглэлийн төрийн нууцыг нууцлах дээд хугацаа 15 жил, нууц зэрэглэлийн төрийн нууцыг нууцлах дээд хугацаа 5 жил байна.

8.2. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 13.1-д заасан ажилтнуудын хувийн байдалтай холбогдсон мэдээллийг уг мэдээлэгчийг нас барснаас хойш 70-аас доошгүй жилээр нууцална

8.3. Энэ хуулийн 8.1-т заасан хугацааг Улсын Их Хурал хуулиар сунгаж болно. Ийнхүү сунгасан хугацаа нь тухайн зэрэглэлийн нууцыг нууцлах дээд хугацаанаас хэтэрч болохгүй.

9 дүгээр зүйл. Мэдээллийг төрийн нууцад хамааруулах журам

9.1. Мэдээллийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9.2. Мэдээ, баримт бичгийг нууцлахдаа төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдэг дарж, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар, нууцлах нийт хугацаа, түүний эхлэх, дуусах он, сар, өдрийг тавина. Нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдгийг хуудас бүрт тавина.

9.3. Эд зүйлийг нууцлахдаа нууцын тэмдэг, төлөөлүүлсэн нэр, шифр, дугаарыг тухайн зүйлийн сав, баглаа боодол, дагалдах баримт бичигт дарж, нууцлах нийт хугацаа, түүний эхлэх, дуусах он, сар, өдрийг тэмдэглэнэ.

9.4. Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг энэ хуульд заасны дагуу Засгийн газраас баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Мэдээллийг төрийн нууцад тооцуулах үндэслэл, журам

10.1. Байгууллага, албан тушаалтан нь тухайн мэдээллийг ил байлгах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитой, ноцтой хор хохирол /хор уршиг, хор аюул/ учруулах үндэслэлтэй гэж үзвэл тухайн мэдээллийг төрийн нууцад тооцуулах саналаа боловсруулж, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлнэ.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан саналд тухайн мэдээллийг төрийн нууцад хамааруулах үндэслэл, шаардлага, гарах үр дагавар, эдийн засгийн тооцоо, судалгааг тусгасан байвал зохино.

10.3. Тагнуулын ерөнхий газар нь энэ хуулийн 10.1-д заасан саналыг хянан үзэж нууцад хамааруулах нь зүйтэй гэж үзвэл, энэ хуулийн 10.2-т заасан зүйлийг хавсарган Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлнэ.

10.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ хуулийн 10.3-т заасны дагуу ирүүлсэн саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Зөвлөлийн хурлаараа хэлэлцэн дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

10.4.1. тухайн мэдээллийг төрийн нууцад хамааруулах нь зүйтэй гэж үзвэл Зөвлөлийн гишүүн бөгөөд хууль санаачлах бүрэн эрх бүхий албан тушаалтны хувьд Монгол Улсын Ерөнхийлөгч, эсхүл Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр шийдвэрлэх;

10.4.2. тухайн мэдээллийг төрийн нууцад хамааруулах шаардлагагүй гэж үзвэл үндэслэл бүхий дүгнэлт гаргах.

10.5. Энэ хуулийн 10.4.2-т зааснаар гаргасан дүгнэлтээ Улсын Их Хурлын төрийн нууцын асуудал эрхэлсэн байнгын хороонд хүргүүлэх ба уг байнгын хороо бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн энэ хуулийн 10.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл тухайн мэдээллийг төрийн нууцын жагсаалтад хамааруулахаар хууль санаачлагч эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

10.6. Төрийн нууцын жагсаалтад мэдээллийг хамааруулах тухай шийдвэр гаргахдаа тэдгээрийн жинхэнэ нэрийг төлөөлүүлсэн нэр, шифр, дугаар хэрэглэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажлын зохион байгуулалт

11 дүгээр зүйл. Төрийн нууцыг хамгаалах нийтлэг асуудал, зарчим

11.1. Төрийн нууцын жагсаалтын тухай хуулиар тогтоосон төрийн нууцыг хадгалж байгаа байгууллага, албан тушаалтан задруулахгүй байх, үрэгдүүлэхгүй байх бүх талын арга хэмжээг авч хамгаалах нийтлэг үүрэгтэй байна.

11.2. Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагаа нь төрийн нууцыг боловсруулах, хадгалах, ашиглах, төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг шилжүүлэх, төрийн нууцтай холбоотой асуудлыг хэлэлцэх хаалттай хуралдаан хийх үйл ажиллагаанаас бүрдэнэ.

11.3. Энэ хуулийн 11.2-т заасан үйл ажиллагааг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан заавар, журмын дагуу хэрэгжүүлнэ.

11.4. Төрийн нууцыг хамгаалах байгууллагын тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Их Хурлын төрийн нууцын асуудал эрхэлсэн Байнгын хороо, түүний Тусгай хяналтын дэд хороо, Засгийн газар, Тагнуулын ерөнхий газар, Хилийн тагнуулын алба, тэдгээрийн салбар, нэгж, төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллагаас бүрдэнэ.

11.5. Төрийн нууцыг хамгаалахад хариуцлагатай байх, хяналттай байх, хурдан шуурхай байх зарчмыг баримтална.

12 дугаар зүйл. Төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх

2.1. Улсын Их Хурал төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1 төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

12.1.2 төрийн нууцын жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталж, төрийн нууцын зэрэглэл, хугацааг тогтоох;

12.1.3. нууцын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.

12.2. Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1. төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын асуудлаар бодлогын баримт бичиг боловсруулах, санал, дүгнэлт гаргах;

12.2.2. төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад дангаараа болон холбогдох байгууллагатай хамтран хяналт, шалгалт хийх;

12.2.3. холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдээс мэдээлэл авах, тайлбар гаргуулах.

12.2.4. энэ хуулийн жил тутам хянан үзсэн тухай тайлангаа холбогдох байгууллагад тодорхой хугацааны дотор хүргүүлнэ.

12.3. Монгол Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын асуудлаар гаргасан дүгнэлтээ Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд бие даан оруулж болно.

12.4. Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.4.1. төрийн нууцын хамгаалалтын бодлогын удирдлагаар хангах;

12.4.2. төрийн нууцыг хамгаалах бодлогын чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай танилцаж, чиглэл өгөх.

12.5. Засгийн газар төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.5.1. төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.5.2. төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны дүрмийг батлах;

12.5.3. төрийн нууцыг боловсруулах, хадгалах, хамгаалах, объект, тодорхой үйл ажиллагааг халхлах, төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг шилжүүлэх, татан авах, хаалттай хуралдаан хийх журмыг баталж, мөрдүүлэх.

12.6. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар нь төрийн нууцыг хамгаалах талаар хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.7. Төрийн нууцыг хамгаалж байгаа төрийн бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.7.1. салбарынхаа хэмжээнд хадгалагдаж байгаа болон бусад байгууллагын хариуцаж буй өөрийн салбарт хамаарах төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих;

12.7.2. мэдээллийг төрийн нууцад тооцуулах, төрийн нууцыг ил болгох асуудлаар холбогдох байгууллагад саналаа оруулах;

12.7.3. төрийн нууцыг татан авах, шилжүүлэх тухай саналаа Тагнуулын ерөнхий газарт оруулах;

12.7.4. төрийн нууцыг тухайн байгууллага хариуцаж буй эсэх талаар хөндлөнгийн этгээдэд тайлбар өгөхөөс татгалзах;

12.7.5. салбарынхаа хэмжээнд хадгалагдаж байгаа болон бусад байгууллагын хариуцаж буй өөрийн салбарт хамаарах төрийн нууцын агуулгыг 5 жил тутам хянаж, энэ хуульд заасан үндэслэл байвал төрийн нууцын жагсаалтаас хасуулах саналаа Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэх;

12.7.6. эрх хэмжээнийхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

12.8. Бүх шатны Засаг дарга нь төрийн нууцыг хамгаалах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд асуудлыг зохих журмаар холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

13 дугаар зүйл. Төрийн нууцыг хадгалах, хамгаалах бусад байгууллагын бүрэн эрх

13.1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага нь өөрт хадгалагдаж байгаа төрийн нууцыг хамгаалах, хяналт тавих арга хэмжээг энэ хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас баталсан заавар, журамд нийцүүлэн зохион байгуулна.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан байгууллага энэ хуулийн 12.7.2-12.7.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл. Байгууллагын даргын эрх, үүрэг

14.1. Энэ хуулийн 12.7-д, 13.1-д заасан байгууллагыг удирдах буюу төлөөлөх эрх бүхий албан тушаалтан /цаашид “байгууллагын дарга” гэх/ тухайн байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах ажлыг Тагнуулын ерөнхий газрын даргын баталсан зааврын дагуу удирдан зохион байгуулах үүрэгтэй байна.

14.2. Байгууллагын дарга дараахь нийтлэг үүргийг хүлээнэ:

14.2.1. төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон заавар журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

14.2.2. төрийн нууцыг хамгаалах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

14.2.3. төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Тагнуулын ерөнхий газартай зөвшилцөн батлах;

14.2.4. байгууллагын хэмжээнд төрийн нууцыг задруулахгүй байх баталгаа гаргах ажлыг удирдан зохион байгуулах.

15 дугаар зүйл. Байгууллагын нууцын эрхлэгч, түүнийг томилох, чөлөөлөх, халах үндэслэл, журмын онцлог

15.1. Байгууллагын нууцын эрхлэгч нь Монгол Улсын иргэн бөгөөд ялгүй этгээд байна.

15.2. Байгууллагын нууцын эрхлэгчийг Тагнуулын ерөнхий газраас шалгаж олгосон зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан томилж, чөлөөлнө.

15.3. Байгууллагын нууцын эрхлэгч нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана. Баталгааны загварыг Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

15.4. Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг хариуцуулахыг хориглоно.

15.5. Төрийн нууцын ажилтан хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд захиргааны шийдвэрээр төрийн нууц хариуцуулахыг зогсоож, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.6. Төрийн нууц хариуцуулахыг зогсоосон нь төрийн нууцыг задруулахгүй байх талаар нууцын эрхлэгчийн урьд нь хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

16 дугаар зүйл. Байгууллагын нууцын эрхлэгчийн үүрэг, эрх, түүнийг түр эзгүйд үүргийг гүйцэтгүүлэх журам

16.1. Байгууллагын нууцын эрхлэгч нь дараахь эрхтэй байна:

16.1.1. төрийн нууцыг хариуцаж буй эсэх талаар хөндлөнгийн этгээдэд тайлбар өгөхөөс татгалзах;

16.1.2. төрийн нууцын хууль тогтоомж, холбогдох журмыг хэрэгжүүлэхийг албан тушаалтнаас шаардах;

16.1.3. хариуцаж байгаа төрийн нууцын зэрэглэл, ажилласан хугацаанаас хамааран холбогдох хуульд заасан журмын дагуу цалингийн нэмэгдэл авах.

16.2. Нууцын эрхлэгч дараахь үүрэгтэй байна:

16.2.1. төрийн нууцын талаархи хууль тогтоомж, холбогдох журмыг мөрдөж ажиллах;

16.2.2. төрийн нууцыг хамгаалах журам зөрчсөн үйлдэл илэрсэн тохиолдолд байгууллагын удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх;

16.2.3. гадаадын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай харъяалах байгууллагадаа мэдэгдэх.

16.3. Нууцын эрхлэгчид дараахь үйлдлийг хийхийг хориглоно:

16.3.1. төрийн нууцыг зохих зөвшөөрөлгүй аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх, танилцуулах;

16.3.2. төрийн нууц, түүнийг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг утсаар болон төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнаас бусад этгээдийн дэргэд ярих;

16.3.3. зохих зөвшөөрөлгүйгээр төрийн нууцтай танилцах, хадгалах, олшруулах, байгууллагаас гаргах, зориулалтын бус газар хадгалах,

16.3.4. зохих зөвшөөрөлгүйгээр гадаадад хувийн хэргээр зорчих

16.4. Байгууллагын нууцын эрхлэгчийн түр эзгүйд түүний ажлыг байгууллагын даргын шийдвэрээр төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд хариуцуулан гүйцэтгүүлнэ. Ажил хүлээлцэх журмыг тагнуулын ерөнхий газрын дарга батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ, АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АШИГЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

17 дугаар зүйл. Төрийн нууцыг илгээх, хүлээн авах журам

17.1. Төрийн нууцын мэдээ, баримт бичгийг битүүмжилж, тусгай тэмдэг тавин төрийн холбооны шуудан, эсхүл дипломат шуудангаар илгээх ба энэ ажлыг нууцын эрхлэгч хариуцан гүйцэтгэнэ.

17.2. Богоно хугацаанд хүргэх шаардлагатай мэдээ, баримт бичгийн агуулгыг нууцлах хэрэгсэл, систем бүхий холбооны хэрэгсэл ашиглан дамжуулж болно. Нууцлах хэрэгсэл, систем бүхий холбооны хэрэгслийг ашиглах боломжгүй бол нууцын зэрэглэлийн тухай дурьдалгүйгээр ердийн журмаар дамжуулж болно.

17.3. Энэ хуулийн 17.1, 17.2-д заасан үйл ажиллагааг Тагнуулын ерөнхий газраас баталсан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

17.4. Төрийн нууцыг байгууллагын нууцын эрхлэгч хүлээн авч Тагнуулын ерөнхий газраас баталсан бүртгэлийн маягтын дагуу бүртгэлд авна.

17.5. Нууцын эрхлэгч хүлээн авсан баримт бичиг, эд зүйлийн бүрдэл дутуу, дугтуй, хайрцаг сав, баглаа задарсан, гэмтсэн байвал энэ тухай байгууллагын даргад танилцуулж, ирүүлсэн байгууллагад мэдэгдэнэ.

17.6. Төрийн нууцыг хүлээн авсан ажилтан түүнийг хүлээн авсан тухай баримт үйлдэн илгээсэн байгууллагад явуулна.

18 дугаар зүйл. Төрийн нууцыг хадгалах, нөхцөл, хэлбэр, журам

18.1. Тухайн байгууллагад байгаа төрийн нууцыг аюулгүй байдлын шаардлагыг хангасан тусгай өрөө, сейф, сав, компьютерт хадгална. Шаардлагатай гэж үзвэл дохиоллын системээр тоноглоно.

18.2. Энэ хуулийн 18.1-д заасан өрөө, сейф, савыг хувийн дугаартай лац тэмдэгээр, компьютерыг нууцлалын шаардлага хангах программаар хангаж тус тус хамгаална.

18.3. Төрийн нууцыг хадгалах зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

19 дүгээр зүйл. Төрийн нууцын архив, түүний статус

19.1. Төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцын ангилал, зэрэглэлээр ангилж бүртгэл хөтлөн үдэлгүй тусгай хавтаст байршуулан архивт хадгална.

19.2. Төрийн нууцын архивын тогтолцоо нь нууцын төв архив, байгууллагын архиваас бүрдэнэ.

19.3. Төрийн нууцын төв архив нь Тагнуулын ерөнхий газрын дэргэд байна. Байгууллагын архив нь тухайн байгууллагын дэргэд байна.

19.4. Байгууллагын архиваас нууцын төв архивт мэдээллийг шилжүүлэх хугацаа, журмыг Засгийн газар батална.

20 дугаар зүйл. Төрийн нууц задруулсан, алдагдсан тохиолдолд авах арга хэмжээ

20.1. Байгууллагын нууцын ажилтан, нууцтай танилцах эрх бүхий этгээд төрийн нууц задарсан, үрэгдсэн, эсхүл ийм нөхцөл байдал үүссэн байж болзошгүй гэж үзвэл байгууллагын даргад танилцуулж, Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэх үүрэгтэй.

20.2. Тагнуулын ерөнхий газар уг мэдээллийг шалгаж холбогдох арга хэмжээг авах үүрэгтэй.

21 дүгээр зүйл. Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан

21.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нь албан ажлын хэрэгцээндээ төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

21.2. Төрийн нууцтай холбогдсон асуудлыг хянан шалгах зорилгоор Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос байгуулсан ажлын хэсгийн дарга, гишүүн тухайн шалгах асуудлын хүрээнд хамаарах төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана. Гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох мэдээ, баримт бичигтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүнээс бусад хүн танилцахыг хориглоно.

21.3. Төрийн нууцыг хариуцаж байгаа төрийн төв, орон нутгийн болон бусад байгууллагын төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Тагнуулын ерөнхий газрын саналыг үндэслэн тухайн байгууллагын дарга батална.

21.4. Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад тухайн албан тушаалтан ямар зэрэглэлийн төрийн нууцтай танилцахыг тусгана.

22 дугаар зүйл. Албан ажлын хэрэгцээндээ төрийн нууц мэдээллийг холбогдох албан тушаалтанд танилцуулах үндэслэл, журам

22.1. Албан ажлын хэрэгцээндээ төрийн нууц мэдээллийг эрх бүхий албан тушаалтанд танилцуулах ажлыг байгууллагын нууцын эрхлэгч, байгууллагын даргын зөвшөөрснөөр хариуцан гүйцэтгэнэ.

22.2. Төрийн нууцтай танилцах албан тушаалтан нууцтай танилцах зорилго, хүлээн авсан хугацаа, буцаан өгөх хугацааг нууцын эрхлэгчид бүртгүүлэн гарын үсэг зурж хүлээн авна.

22.3. Төрийн нууцтай танилцах албан тушаалтан аюулгүй байдлыг хангасан албаны өөрөө тасалгаанд төрийн нууцтай танилцана.

22.4. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг албан ажлын зорилгоор байгууллагын даргын зөвшөөрлөөр нууцын эрхлэгч хувилан олшруулж танилцуулж болно. Хувилсан мэдээ, баримт бичгийн хуудас бүр дээр нууцын эрхлэгч гарын үсэг зурж баталгаажуулна.

22.5. Хувилж олшруулсан нууц мэдээ, баримт бичгийг ашиглаж дууссаны дараа нууцын эрхлэгч хүлээн авч устгах арга хэмжээ авна.

22.6. Байгууллагын нууцын эрхлэгчээс өөр албан тушаалтан төрийн нууцыг хувилж олшруулж болохгүй.

23 дүгээр зүйл. Албан ажлын шаардлагаар төрийн нууц мэдээлэлтэй танилцсан ажилтны үүрэг, эрхийн хязгаарлалт

23.1. Албан ажлын шаардлагаар төрийн нууц мэдээлэлтэй танилцсан албан тушаалтанд энэ хуулийн 15.3-т заасны адил баталгаа гаргана.

23.2. Төрийн нууц мэдээлэлтэй танилцсан албан тушаалтанд тухайн албан тушаалаас өөрчлөгдсөн, чөлөөлөгдсөн, халагдсан нь түүнийг төрийн нууцын талаар хүлээсэн үүргээс нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

24 дүгээр зүйл. Төрийн нууц мэдээллийг татан авах, шилжүүлэх

24.1. Төрийн нууцыг дараахь тохиолдолд Тагнуулын ерөнхий газар татан авна:

24.1.1. төрийн нууцыг хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс төрийн нууц задрах бодит нөхцөл байдал бий болсон;

24.1.2. тухайн байгууллага татан буугдсан буюу өөрчлөн байгуулагдсаны улмаас төрийн нууцыг хариуцах үүрэггүй болсон;

24.1.3. төрийн нууцыг тухайн байгууллага өөрийн хүчээр хамгаалах боломжгүй болсон.

24.2. Төрийн нууцыг Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрлөөр нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН НУУЦЫГ ИЛ БОЛГОХ

25 дүгээр зүйл. Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам

25.1. Төрийн нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно:

25.1.1. нууцлах хугацаа дуусгавар болсон;

25.1.2. нууцлах шаардлагагүй болсон;

25.1.3. энэ хуулийн 25.4-д заасан үндэслэлийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн;

25.1.4. хуульд заасан бусад үндэслэл.

25.2. Төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага нь төрийн тухайн нууцын нууцлах хугацаа дуусгавар болмогц түүнийг ил болгон энэ тухай Тагнуулын ерөнхий газарт албан бичгээр мэдэгдэж, нийтэд мэдээлнэ.

25.3. Төрийн нууцыг хадгалж байгаа байгууллага нь ач холбогдлоо алдсан буюу бодит нөхцөл байдлын улмаас тухайн нууцыг төрийн хамгаалалтад байлгах шаардлагагүй гэж үзвэл төрийн тухайн нууцыг хугацаанаас нь өмнө ил болгох саналаа Тагнуулын ерөнхий газарт хүргүүлнэ.

25.4. Төрийн тухайн нууц нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, бүх төрлийн нөөцийг зүй зохистой ашиглахад бодит хор хохирол учруулахаар байна гэж үзэж иргэн, хуулийн этгээд түүнийг ил болгох хүсэлтийг Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж болно.

25.5. Энэ хуулийн 25.3, 25.4-д заасны дагуу хүргүүлсэн төрийн нууцыг ил болгох саналыг энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

25.6. Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 25.3, 25.4-т заасан саналыг ирүүлсэн байгууллага, албан тушаалтан, иргэнд тухайн саналыг энэ хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж дууссаны дараа шийдвэрлэсэн байдлын талаар албан бичгээр мэдэгдэнэ. Тухайн мэдээллийг ил болгохоос татгалзсан бол үндэслэлийг нь тусгасан байна.

25.7. Энэ хуульд заасны дагуу ил болгосон төрийн нууцыг Үндэсний төв архивт 30 хоногийн дотор шилжүүлж, хадгалах хугацааг Архивын тухай хуулиар зохицуулна.

26 дугаар зүйл. Төрийн нууцад хамаарахгүй мэдээллийг нууцлахыг хориглох

26.1. Төрийн байгууллага төрийн нууцад хамаарахгүй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй байна.

26.2. Төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдгийг төрийн байгууллага, албан тушаалтанд төрийн нууцад үл хамаарах мэдээлэлд хэрэглэхийг хориглоно.

27 дугаар зүйл. Төрийн нууцтай танилцах хүсэлт гаргах

27.1. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичигтэй танилцах хүсэлтийг иргэн, хуулийн этгээд гаргаж болно. Хүсэлтэд овог нэр, оршин суугаа хаяг, зорилгыг тодорхой тусгасан байна.

27.2. Энэ хуулийн 27.1-д заасан хүсэлтийг Тагнуулын ерөнхий газар хянан үзэж зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хүсэлт гаргаснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж зохих хариуг өгнө.

27.3. Энэ 27.2-т заасны дагуу зөвшөөрөл олгосон бол төрийн нууцтай танилцсан этгээд задруулахгүй байх тухай баталгааг гаргаж өгнө.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН НУУЦЫГ ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТАД ТАВИХ ТӨРИЙН ХЯНАЛТ, АРГАЧИЛСАН УДИРДЛАГА

28 дугаар зүйл. Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад тавих хяналтын тогтолцоо

28.1. Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт хяналт тавих тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Их Хурлын төрийн нууцын асуудал эрхэлсэн Байнгын хороо, түүний Тусгай хяналтын дэд хороо, Засгийн газар, Тагнуулын ерөнхий газар, Хилийн тагнуулын алба, тэдгээрийн салбар, нэгж, төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллагын дотоод хяналтаас бүрдэнэ.

28.2. Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт хяналт тавих байгууллага, албан тушаалтан холбогдох хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

29 дүгээр зүйл. Тагнуулын төв газар, түүний эрх үүрэг

29.1. Тагнуулын ерөнхий газар нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалтыг аргачилсан удирдлагаар хангаж, түүний хэрэгжилтийг хянаж, шалгаж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

29.2. Тагнуулын ерөнхий газар нь төрийн нууцын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.2.1. төрийн нууцын хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

29.2.2. төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан төрийн нууцын хууль, түүнд үндэслэн гарсан дүрэм, журам, зааврын биелэлтэд хяналт тавих, шалгах;

29.2.3. төрийн нууцыг хадгалах, хамгаалах, шилжүүлэх, танилцуулах ажлыг боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

29.2.4. төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичгийг дамжуулах төрийн холбоо, шуудан, шифр, тоон мэдээллийн харилцааны сүлжээгээр үйлчлэх;

29.2.5. төрийн нууцыг үрэгдүүлсэн, устгасан, задруулсан тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

29.2.6. төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

29.2.7. хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

30 дугаар зүйл. Байгууллагын дотоодын хяналт

30.1. Байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх журмыг Тагнуулын ерөнхий газраас баталсан аргачлалын дагуу байгууллагын дарга баталж мөрдүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХАРИУЦЛАГА

31 дүгээр зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

31.1. Төрийн нууцын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн, захиргааны, сахилгын, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

31.2. Төрийн нууцыг задруулсан, үрэгдүүлсэн, төрийн нууцын талаархи журам зааврыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

31.3. Төрийн нууцын хадгалах, хамгаалах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч Захиргааны хариуцлагын хуульд заасан шийтгэлийг хүлээлгэхээс гадна энэ хуулийн дор дурдсан зүйл, заалтыг зөрчсөн этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

31.3.1. төрийн нууцын зэрэглэлийг тодорхойлсон тэмдгийг төрийн нууцад үл хамаарах мэдээлэлд хэрэглэсэн бол албан тушаалтныг 25000-50000 төгрөгөөр торгох;

31.3.2. энэ хуульд заасан болон энэ хуулийн дагуу гарсан заавар, дүрэм, журмыг зөрчсөн төрийн нууцын ажилтныг зөрчлийн шинж байдлыг харгалзан 10000-60000 төгрөгөөр торгох.

31.3.3. энэ хуульд заасан болон энэ хуулийн дагуу гарсан заавар, дүрэм, журмыг төрийн нууцын ажилтанг биелүүлэх явцад түүнд зохих дэмжлэг үзүүлээгүй болон саад болсон албан тушаалтанг 50000-60000 төгрөгөөр торгох

31.4. Энэ хуульд заасан болон энэ хуулийн дагуу гарсан дүрэм, журмыг зөрчсөн нь байгууллагын нууцын эрхлэгч, төрийн нууцтай албан ажлын хэрэгцээгээр танилцсан албан тушаалтныг албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж үзэн сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас халах үндэслэл болно.

31.5. Төрийн нууцын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эсхүл төрийн нууцын хадгалах, хамгаалах журмыг зөрчснөөс байгууллагын нууцын эрхлэгч, төрийн нууцтай албан ажлын хэрэгцээгээр танилцсан болон бусад албан тушаалтны бусдад хохирлыг тухайн албан тушаалтны харъяалах байгууллага хариуцаж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Бусад зүйл

32 дугаар зүйл.Төрийн нууц хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх

32.1.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

ГАРЫН ҮСЭГ